

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 08 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

Г Үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ г явуулах эрхийг түдгэлзүүлэх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестачилах тухай журам”-ын 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Батс” ХХК-ийн дилер Очир овогтой Энхбаатарын /регистрийн дугаар ШЗ72092371/ үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрхийг 2010 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсүгэй.

2. Дилер О.Энхбаатарыг Хөрөнгийн биржийн арилжаанд оролцуулахгүй байхыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, түдгэлзүүлсэн хугацаагаар үүрэгт ажлаас нь түр чөлөөлөхийг “Батс” ХХК /Н.Батнасан/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН